Төрийн сангийн үйл ажиллагааны
журмын 1 дүгээр хавсралт
Маягт ТТ-1

# ТӨЛБӨРИЙН ХҮСЭЛТ № **00572**

2020 оны 12 сарын 23 өдөр

| Байгууллагын нэр: **Эрүүл мэндийн яам** | Дансны дугаар | Дүн тоогоор |
|---|---|---|
| Регистрийн дугаар: **9087443** | **100900020001** | **848,100,000.00** |
| Хүлээн авагчийн нэр: **Медстар Эрдэнэ ХХК** | Дансны дугаар | |
| Регистрийн дугаар: **5281113** | **452528398** | |
| Хүлээн авагчийн банк: **Худалдаа Хөгжлийн Банк** | | |
| Мөнгөн дүн үсгээр: **Найман зуун дөчин найман сая нэг зуун мянган төгрөг** | Ангилал | |
| Гүйлгээний утга: ЭМДТөв-д шаардлагатай тон.төх багц /Багц-3/ Г.Бат-эрдэнэ | 71601 - Нийгмийн эрүүл мэнд<br>81605 - Эрүүл мэндийг дэмжих<br>0000 - Төрийн сан<br>210601 - Багаж, техник, хэрэгсэл | 848,100,000.00 |

| Хяналтын хуудас №: 00572 | | |
|---|---|---|
| Үндэслэх бичиг баримтын нэр | Үндсэн баримтын он сар дугаар | Төрийн сангийн тэмдэглэл |
| 1.Нэхэмжлэх | 2020.12.03 | |
| 2.Медстар ХХК албан тоот | 2020.12.03 | |
| 3.Техникийн комиссын урьдчилсан дүгнэлт | 2020.11.30 | |
| 4.ТНБД-ын Үнэлгээний хорооны тушаал А/86 | 2020.09.09 | |
| 5.Үнэлгээний тайлан | ЭМЯ/2020/09/17 | |
| 6.Тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ | №366 | |
| 7.Гэрээний нэмэлт өөрчлөлт | №437 | |

Тамга

Гарын үсэг

Дарга .................................... Я.Амаржаргал

Нягтлан бодогч .................................... Э.Эрдэнэцэцэг

Төрийн санд гүйлгээ хийсэн
....оны.....сарын.....өдөр
Тэмдэг, гарын үсэг

БАТЛАВ:

| ЗАХИАЛАГЧ: | НИЙЛҮҮЛЭГЧ: |
|---|---|
| ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА | “МЕДСТАР ЭРДЭНЭ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ |
| Я.АМАРЖАРГАЛ | Н.ЗОРИГСАЙХАН |

**ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ТӨВД ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, /БАГЦ-№3: ЧИХ, ХАМАР, ХООЛОЙН ОНОШИЛГООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ/ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар № 366

Улаанбаатар хот

Нэг талаас “ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ” (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “МЕДСТАР ЭРДЭНЭ” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай тоног төхөөрөмж Багц-№3: “Чих, хамар, хоолойн оношилгооны тоног төхөөрөмж”-ийг нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг хүлээн зөвшөөрч гэрээ байгуулав. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 848,100,000₮ /Найман зуун дөчин найман сая нэг зуун мянга/ төгрөгөөр Улсын төсвийн хөрөнгөөс санхүүжүүлнэ. 2020 онд санхүүжих дүн 848,100,000₮ /Найман зуун дөчин найман сая нэг зуун мянга/ төгрөгийг тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсний дараа нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь доорх нэр төрлийн барааг, талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 18-30 хоногийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5.

| № | Барааны нэр | Барааны гарал үүсэл | Марк | Тоо ширхэг |
|---|---|---|---|---|
| 1 | | 2 | 3 | 4 |
| 1 | Тимпанаметр | Итали улс | M.R.S SRL Co.,ltd R26M | 6 ширхэг |
| 2 | Аудиометр | Итали улс | M.R.S SRL Co.,ltd R37M | 6 ширхэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Чих хамар хоолойн үзлэгийн дуран | БНСУ | Medstar Co.ltd Medvision | 6 ширхэг |
| 4 | Чих хамар хоолойн ширээ ком /Өвчтөний сандлыг хамт/ | БНСУ | Medstar Co.ltd UE-3000 ширээ MC-4000 өвчтөний сандал | Тус бүр 6 ширхэг |

6. Захиалагч болон нийлүүлэгч байгууллагын зүгээс үл хамаарсан хүчин зүйлсийн улмаас гэрээний зарим зүйл заалт биелүүлэх хугацаа хойшлогдсон тохиолдолд хоёр тал харилцан тохиролцож, зөвшилцөн шийдвэрлэнэ.

7. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Бусад шаардлагатай баримт бичиг;
Тендерийн баталгаа;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь;
Баталгаат хугацааны мэдэгдэл /албан тоот/
Гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл /албан тоот/

8. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

9. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

10. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

11. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

Д.Нарантуяа

Хуулийн хэлтсийн дарга

М.Ганзориг

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"Медстар Эрдэнэ" ХХК-ний захирал

Н.Зоригсайхан

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер

Б.Чинбат

Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Т.Бямбасүрэн

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер

Б.Цэрэндорж

Хуулийн хэлтсийн гэрээний мэргэжилтэн

Д.Мөнхцэцэг

Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Г.Бат-Эрдэнэ

Хаяг: Эрүүл мэндийн яам, Засгийн газрын VIII байр, 1 давхар 106 тоот өрөө Улаанбаатар-48, Олимпын гудамж-2
Утас: 51-263631, Факс: 323541

Хаяг: Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, UBH оффисын барилга 2 давхар,206 тоот
Утас: 7000-3990, 9190-3790
И-мэйл: medstar.erdene@gmail.com
Дансны дугаар: 452 528 398
Худалдаа, хөгжлийн банк

БАТЛАВ:

| ЗАХИАЛАГЧ: | НИЙЛҮҮЛЭГЧ: |
|---|---|
| ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА | “МЕДСТАР ЭРДЭНЭ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ |
| Я.АМАРЖАРГАЛ | Н.ЗОРИГСАЙХАН |

# ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ТӨВД ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, /БАГЦ-№3: ЧИХ, ХАМАР, ХООЛОЙН ОНОШИЛГООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ/ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ-1

Дугаар № ...437

Улаанбаатар хот

Нэг талаас “Эрүүл мэндийн яам” (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Медстар Эрдэнэ” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай тоног төхөөрөмж Багц-№2: “Чих, хамар, хоолойн оношилгооны тоног төхөөрөмж” нийлүүлэх 366 тоот гэрээний хүчинтэй хугацаанд өөрчлөлт оруулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Нийлүүлэгч байгууллагын зүгээс дэлхий дахинд үүсээд байгаа цар тахлын улмаас тогтоосон хөл хорионоос үүдэн гэрээнд заасан барааны нийлүүлэх хугацааг сунгах тухай 20/071 тоот хүсэлт, гэрээний ерөнхий нөхцөлийн 16 дугаар зүйлийн 16.2.(в) заалтыг тус тус үндэслэн бараа нийлүүлэлтийн эцсийн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл сунгахыг харилцан тохиролцож гэрээний нэмэлт өөрчлөлтийг байгуулав.

3. Энэхүү гэрээ нь 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 366 дугаартай гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлага хэвээр хадгалагдана.

| **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** | **НИЙЛҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨӨЛЖ** |
|---|---|
| Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер |
| Д.Нарантуяа | Б.Чинбат |

Хуулийн хэлтсийн дарга

Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Т.Бямбасүрэн

Хуулийн хэлтсийн гэрээний мэргэжилтэн

Д.Мөнхцэцэг

Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Г.Бат-Эрдэнэ

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер

Б.Цэрэндорж

Хаяг: Эрүүл мэндийн яам, Засгийн газрын VIII байр, 1 давхар 106 тоот өрөө Улаанбаатар-48, Олимпын гудамж-2
Утас: 51-263631, Факс: 323541

Хаяг: UBH center 206 тоот
Утас: 976-70003990,91903790
И-мэйл:medstar.erdene@gmail.com
Дансны дугаар: ХХБ 452 528 398

## ТЕХНИКИЙН КОМИССЫН УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ

2020 оны 11 дугаар сарын 30 №84/2020 Улаанбаатар хот

### НЭГ.

1.1 Гэрээний нэр, дугаар, огноо: **Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай тоног төхөөрөмж, Дугаар № 366,** 2020 оны 10 дугаар сарын 29-ны өдөр,

1.2 Тоног төхөөрөмжийн нэр: **Багц 3. Чих, хамар хоолойн оношилгооны тоног төхөөрөмж**

1.3 Захиалагч байгууллага: **Эрүүл мэндийн яам**

1.4 Нийлүүлэгч байгууллага: **"Медстар Эрдэнэ" ХХК**

1.5 Эрүүл мэндийн сайдын 2018 оны **А/317** дугаар "Техникийн комисс шинэчлэн байгуулах, журам батлах тухай" тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь батлагдсан удирдамжийн дагуу захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг гэрээний хавсралт, ерөнхий болон тусгай нөхцөлд тусгагдсан шаардлагыг хангасан байдал, барааны чанар, тээвэрлэлт, хадгалалтын байдал болон тоног төхөөрөмжийн холбогдох баримтуудыг үндэслэн багаж, тоног төхөөрөмжийн марк, модел, техник үзүүлэлт таарч буй эсэхэд шалгаж техникийн комиссын урьдчилсан дүгнэлтийг гаргав.

### ХОЁР.

2.1 Гүйцэтгэгч байгууллага гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжүүд 2020.11.30-ны өдөр тус компаний агуулахад үзээд, баримт бичигт тулгалт хийж, хүлээн авагч эрүүл мэндийн байгууллагын ашиглалтад хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэв.

2.2 Гүйцэтгэгч захиалагчаас өгсөн багаж, тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудад хүргэж, суурилуулж, ашиглалтын сургалтыг явуулж, **2** жилийн хугацаанд баталгаат засварыг бүрэн хариуцаж, сэлбэг хэрэгслээр хангана.

2.3 Техникийн комиссын урьдчилсан дүгнэлт, холбогдох баримт бичиг, материалыг 3 хувь үйлдэж захиалагч, гүйцэтгэгч, хүлээн авагч байгууллага тус бүрт 1 хувийг хүргүүлнэ.

2.4 Техникийн комиссын урьдчилсан дүгнэлт нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

- Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт
- Баталгаат засварын хугацаа, үйлчилгээ, тохиргооны батлагдсан хуваарь

### ГУРАВ. БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ҮНЭ, ТОО ШИРХЭГ

| № | Барааны нэр | Барааны гарал үүсэл | Марк, тип | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тимпанаметр | Итали M.R.S SRL Co.,Ltd | R26M | 6 | 31,991,667 | 191,950,000 |
| 2 | Аудиометр | Итали M.R.S SRL Co.,Ltd | R37A | 6 | 33,091,667 | 198,550,000 |
| 3 | Чих, хамар, хоолойн үзлэгийн дуран | БНСУ Medstar Co.,Ltd | Medvision | 6 | 31,533,333 | 189,200,000 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Чих, хамар, хоолойн ширээ ком /Өвчтний сандлын хамт/ | БНСУ Medstar Co.,Ltd | UE-3000 | 6 | 44,733,333 | 268,400,000 |
| **НИЙТ** | | | | | | **848,100,000** |
| **Найман зуун дөчин найман сая нэг зуун мянган төгрөг** | | | | | | |

## ДӨРӨВ. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

| Д/д | Гэрээнд тусгагдсан техник үзүүлэлт | Шаардлага хангасан эсэх |
|---|---|---|
| **1. Тимпанаметр**<br>Үйлдвэрлэсэн улс: **Итали**<br>Үйлдвэрлэгч: **M.R.S SRL Co.,Ltd**<br>Загвар: **R26M**<br>**ШААРДЛАГА ХАНГАЖ БУЙ ЭСЭХ: ТИЙМ** | | |
| | - Дунд чихний оношилгоог хийх зориулалттай<br>- Тест хийх төрөл: Tympanometry, Acoustic Reflex, Reflex, Decay, Quick check, Quick Screening, Milti frequency tympanometry<br>- Дэлгэц: 7 инч ба түүнээс дээш TFT дэлгэцтэй<br>- Олон хэлний сонголттой<br>- Өөр дээрээ принтертэй, принтерийн стандарт цаас дагалдуулна<br>- Үр дүнг өөр дээрээ хадгаладаг, өвчтөний мэдээллийг USB дээр хадгалдаг, мэдээллийг компьютер руу зөөвөрлөх боломжтой<br>- Холбогдох порт: USB<br>- Цахилгаан тэжээл: 220В/50Гц<br>- Датчик:<br>  - 226Hz for Admittance curve tympanometry<br>  - 1000Hz for Admittance curve tympanometry with added Susceptance and Conductance curves<br>- Агаарын даралт:<br>  - Хяналт Автомат<br>  - Хүрээ: +200аас -400 daPa алхмаар тохируулах боломжтой<br>  - Даралтын нарийвчлал: ±10 daPa эсвэл ± 10 %<br>  - Хэмжээс: 50, 100, 200, 300 daPa.сек<br>  - Индикатор: Дэлгэцэн дээр хэмжээг харуулдаг<br>  - Аюулгүйн хязгаарлалт: -800+600daPa<br>- Acoustic reflex tests<br>  - Тест хийх арга: Threshold, автомат, гар ажиллагаатай<br>  - Үргэлжлэх хугацаа: 0.5, 1.2 sec<br>  - Хэрэглэгч өөрийн хэрэглэх аргаа сонгох боломжтой<br>- Давтамжийн хүрээ:<br>- Ipsilateral:<br>  - Цэвэр дууны түвшиний хүрээ dBHL:50-100<br>  - Чимээний тзүвшиний хүрээ dBHL:50-100<br>  - Давтамж: 500, 1000, 2000, 3000, 4000Hz<br>  - Дуу чимээ: BBN8 HP or LP<br>  - Давтамжийн нарийвчлал:±1%<br>  - Гажуудал THD:3% аас бага<br>- Contralateral:<br>  - Цэвэр дууны түвшний хүрээ dBHL:50-120 | **Хангасан** |

| | |
|---|---|
| - Дуу чимээ: BBN, HP or LP<br>- Давтамжийн нарийвчлал: ±1%<br>- Тохируулгын нарийвчлал: ±3dB<br>- Түвшний алхам: 1,2,5 or 10dB<br>- On, off харьцаа : 70dB<br>- Стандарт иж бүрдэлтэй | |
| **2. Аудиометр**<br>Үйлдвэрлэсэн улс: **Итали**<br>Үйлдвэрлэгч: **M.R.S SRL Co.,Ltd**<br>Загвар: **R37A**<br>**ШААРДЛАГА ХАНГАЖ БУЙ ЭСЭХ: ТИЙМ** | |
| - Иж бүрдэл:<br>  - үндсэн аппарат/аудиометр/<br>  - агаар дамжуулалтын хүлээн авагч / air conduction receiver/<br>  - дуу чимээ ясанд дамужжлалтын хүлэ авагч /bone conduction receiver/<br>  - микрофон<br>  - өвчтөнд зориулсан товчлуур /Patient response switch/<br>  - аудиограммын цаас<br>- Тестийн давтамж: 125Гц, 205Гц, 500Гц, 750Гц, 1кГц, 1.5кГц, 2кГц, 3Кгц, 4кГц, 6кГц, 8кГц, 9кГц, 10кГц, 11.2кГц, 12.5кГц, 14кГц, 16кГц<br>- Дуу чимээний түвшин: 5дБ, 2дБ, 1дБ<br>- Дохионы төрлүүд: үргэлжилсэн – pure tone, цохилттой алхамт – pulse tone, чичигнэсэн –warble noise, бага чимээтэй дуу narrowband noise, их чимээтэй дуу- broadband noise<br>- Функц: Tone presenter/ interrupter, Interlock (tone presentation of both channels simutaneously), channel swap, tracking (fixed level defference between both channels), mixing (ipsilateral presentation of), talk forward, talk backm monitor phone, assistens phone<br>- Цахилгаан тэжээл: 220В/50Гц | **Хангасан** |
| **3. Чих, хамар, хоолойн үзлэгийн дуран**<br>Үйлдвэрлэсэн улс: **БНСУ**<br>Үйлдвэрлэгч: **Medstar Co.,Ltd**<br>Загвар: **Medvision**<br>**ШААРДЛАГА ХАНГАЖ БУЙ ЭСЭХ: ТИЙМ** | |
| - Цахилгаан тэжээл: 220В/50Гц<br>- Чадал: 220Вт<br>- Өнгөний температур: 3000Т/хамгийн ихдээ/<br>- Гэрэлтүүлгийн урсгал: 720Ln<br>- Гэрлийн эх үүсвэр: галолен, 15В/150 Вт<br>- Гэрлийн ажиллах хугацаа: 100 цаг<br>- Дэлгэцэн харуулах: 1/2/4 дүрсээр харуулах, NTSC/PAL<br>- Камер: 1/3 хэмжээст, энгийн чип, 520К пиксель<br>- 19 инчийн лед дэлгэцтэй<br>- Доороо дугуйтай тул зөөврлөхөд хялбар<br>Нэмэлтээр: Дагалдуулах дуран: Герман улсын **Karl Storz**<br>- Чихний үзлэгийн 0°, 90мм урттай, 2,7 *Øтай* дуран 1 ширхэг | **Хангасан** |
| **4. Чих, хамар, хоолойн ширээ ком /Өвчтний сандал**<br>Үйлдвэрлэсэн улс: **БНСУ**<br>Үйлдвэрлэгч: **Medstar Co.,Ltd** | |

| Загвар: **UE3000, MC4000**<br>**ШААРДЛАГА ХАНГАЖ БУЙ ЭСЭХ: ТИЙМ** | |
|---|---|
| - Сорох систем: 680mmHg-100l/min хүчин чадалтай<br>- Шүрших систем: 2,5kg/cm$^2$-10l/min<br>- Шүршигчийн тоо хэмжээ: шулуун -2ш, муруй – 1ш<br>- Мэдрэгчтэй самбартай<br>- Цахилгаан тэжээл: 220В/50Гц<br>- LCD 24 инчийн монитортой<br>- Бүх хэсгүүд мэдрэгчээр ажилладаг тул орчин үеийн, ажиллахад хялбар<br>- Рентген зураг харах тод лед гэрэл бүхий өргөн, том дэлгэцтэй /Негатоскоп/<br>- Дотоод гол эд анги болох:<br>    - мотор – Япон улсад үйлдвэрлэсэн<br>    - эм шүршигч - Япон улсад үйлдвэрлэсэн<br>    - тоосруулж шүршигч -Япон улсад үйлдвэрлэсэн тул чанартай<br>- **Өвчтөний сандал MC-4000:**<br>  - Цахилгаан тэжээл: 220В/50Гц<br>  - Эргэлт: 3400<br>  - Дээш өргөх, доошоо буулгах автомат тохируулгатай<br>  - Гарын түшлэг: 3600<br>  - Толгойн түшлэг: тохируулах боломжтой<br>  - Өндөр:<br>    - суудлын өндөр : 500-540 мм<br>    - нурууны түшлэгийн өндөр: 1300-1400мм<br>  - Хөл педальтай<br><u>Нэмэлтээр:</u><br>- **Өөр дээрээ үзлэгийн дурангийн иж бүрдэлтэй – Medvision**<br>- **Дагалдуулах дурангууд**: Герман улсын **Karl Storz**<br>  - чихний үзлэгийн 0°, 90мм урттай, 2,7 *∅тай* дуран 1 ширхэг<br>  - хамрын 0°, 175мм урттай, 2,7 ∅ *– тай* дуран 1 ширхэг<br>  - өвөнхийн 70°, 185мм, 6∅ *– тай* дуран 1ширхэг<br>- **Дуран ариутгагч төхөөрөмж 1 ширхэг - Medstar EDS-500**<br>    - AC220V, 50/60Hz, 10W<br>    - 316 x 150.5 x390мм, 8.5кг<br>    - Кварцын гэрлээр 3 минутын дотор дуранг ариутгах бөгөөд нэг удаад тасралтгүй 30 минут ажиллах хүчин чадалтай.<br>- **360°-ийн эргэлттэй эмчийн сандал 1 ширхэг – Medstar MS-501**<br>    - Зөөлөн подушкатай, цэвэр арьсан бүрээстэй<br>    - Эмчийн хөдөлгөөнийг хязгаарлахааргүй түшлэгтэй<br>    - Дугуйтай тул эмч өвчтөн болон ширээ рүү чөлөөтэй хүрч очих боломжтой<br>    - Өндөр, намыг тохируулж болдог<br>- **Эмчийн үзлэгийн духны гэрэл 1 ширхэг - Medstar MH-500**<br>    - Хагалгааны тохируулдаг гэрэл буюу сарнидаггүй Лүүптэй, лед гэрэлтэй<br>    - 220V цахилгаан болон Lithium батерейгаар ажиллах 2 төрлийн горимоор ажиллана. Батерейгаар тасралтгүй 8 цаг ажиллах хүчин чадалтай. Үзлэг болон хагалгааны аль алинд ашиглах боломжтой | **Хангасан** |

## ТАЙЛБАР, ДҮГНЭЛТ:

1. **Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай тоног төхөөрөмж, Дугаар № 366** гэрээний дагуу нийлүүлэгдэж буй **4** нэр төрлийн тоног төхөөрөмжтэй

танилцаж, баримт бичигтэй тулгалт хийхэд техникийн шаардлага хангаж байна.

2. Медстар Эрдэнэ ХХК нь тендерийн техникийн шаардлагаас гадна дараах тоног төхөөрөмж, хэрэгслийг **нэмэлтээр үнэ төлбөргүй** нийлүүлж байна. Үүнд:
   2.1 Чих, хамар, хоолойн ширээний ком-д: тус бүр
   a) Үзлэгийн дурангийн иж бүрдэл - 1 ширхэг - **Medvision**
   b) Чихний үзлэгийн 0°, 90мм урттай, 2,7 Øтай дуран - 1 ширхэг
   c) хамрын 0°, 175мм урттай, 2,7 Ø – тай дуран - 1 ширхэг
   d) Төвөнхийн 70°, 185мм, 6Ø – тай дуран - 1 ширхэг
   e) Дуран ариутгагч төхөөрөмж 1 ширхэг - **Medstar EDS-500**
   f) 360°-ийн эргэлттэй эмчийн сандал 1 ширхэг – **Medstar MS-501** загвар
   g) Эмчийн үзлэгийн духны гэрэл 1 ширхэг - **Medstar MH-500**
   2.2 Чих, хамар, хоолойн үзлэгийн дуранд: тус бүр
   a) Чихний үзлэгийн 0°, 90мм урттай, 2,7 Øтай дуран - 1 ширхэг
3. Ханган нийлүүлэгч байгууллагын зүгээс:
   - Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон аюулгүй ажиллагааны зааварчилгааг Монгол хэл дээр бэлтгэн хүлээн авагч байгууллагад өгөх
   - Гэрээнд заагдсан дагалдах хэрэгслийн тоо ширхэг, нэр төрлийн дагуу хүлээлгэн өгөх
   - Холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтэнд ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээний сургалт зохион байгуулах шаардлагатай.
4. Ашиглагч байгууллагын зүгээс:
   - Гэрээнд заагдсаны дагуу тоног төхөөрөмжийн дагалдах хэрэгслийн тоо ширхэг, нэр төрлийн дагуу мөн холбогдох баримт бичгийг нэг бүрчлэн хүлээж авах шаардлагатай.

**УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ ГАРГАСАН:**
**Техникийн комиссын дарга:**

ЭМЯ-ны Эм, үйлдвэрлэл, технологийн газрын дарга Н.Гэрэлт-Од

**Нарийн бичгийн дарга:**
ЭМЯ-ны ЭҮТГазрын Эрүүл мэндийн техник, тоног төхөөрөмж, хэмжлийн нэгдмэл байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Сансармаа

**Гишүүд:**
ЭМЯ-ны ЭЗСХОГазрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Бат-Эрдэнэ

ЭМХТ, ЭЭТТАлбаны Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, судалгаа, мэдээний сан хариуцсан мэргэжилтэн Б.Батцоож

ЭМХТ, ЭЭТТАлбаны Эмнэлгийн тоног засвар үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Б.Санж-Очир

ЭМХТ, ЭЭТТАлбаны Эмнэлгийн тоног төхөөрөмжийн
шалгалт баталгаажуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Халиунаа

**ЗӨВШӨӨРСӨН:**

"Медстар Эрдэнэ" ХХК-ий Захирал Н.Зоригсайхан

"Медстар Эрдэнэ" ХХК-ий инженер Б.Цэрэндорж

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 9 сарын 09 өдөр Дугаар А/86 Улаанбаатар хот

## Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсэг, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн яамны багаж, хэрэгслийн зардлаас 8,400,000,000 (найман тэрбум дөрвөн зуун сая) төгрөгөөр худалдан авах "Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай тоног төхөөрөмж" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | |
|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | Н.Гэрэлт-Од, Эм, үйлдвэрлэл, технологийн газрын дарга |
| Нарийн бичгийн дарга: | Н.Норовбанзад, Хөрөнгө оруулалтын хэлтсийн зохион байгуулагч |
| Гишүүд: | М.Гэрэлтуяа, Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн<br>Р.Дуламжав, "Нийгмийн хөгжлийн ертөнц" төрийн бус байгууллагын тэргүүн /зөвшилцсөнөөр/<br>Х.Хулан, "Сэтгэлийн сувилахуй" төрийн бус байгууллагын гишүүн /зөвшилцсөнөөр/ |

2. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга /Г.Гэрэлт-Од/-д даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, яамны холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Н.Норовбанзад/-д үүрэг болгосугай.

ДАРГА Я.АМАРЖАРГАЛ